



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-
ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
НАМЧИНХАНДЫН ГЭРЭЛЧУЛУУН
ТАНАА

2024.08.09 № 01/827
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Намчинхандын Гэрэлчулууны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Намчинхандын Гэрэлчулууны Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Намчинхандын Гэрэлчулууны сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Намчинхандын Гэрэлчулуунд

Хувийг: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР


ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ НАМЧИНХАНД ОВОГТОЙ ГЭРЭЛЧУЛУУН
МИНИЙ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ:Ерөнхий агуулга

Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийг төлөөлөн эрх ашгийг хамгаалах талаар манлайлан оролцож төлөөлөгчийн үүргээ бүрэн бүелүүлэн ажиллах

ХОЁР: Хөтөлбөрийн үндсэн заалт

- ❖ Залуучуудын хөгжил, хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдрах, хөдөлмөр эрхлэлт, мэргэжил олгох бүх төрлийн сургалт зохион байгуулж дэмжиж ажиллах
- ❖ Хүүхэд залуучуудын авьяас чадварыг нээн илрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх талаар сумын соёл урлагийн байгууллагатай хамтарч ажиллах
- ❖ Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмол үйл ажиллагаатай болгон хүүхдийн эрхийг хамгаалахад манлайлан ажиллана.
- ❖ ИТХ-ын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, сумын хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулдаг байхад анхаарч ажиллана
- ❖ Жижиг үйлдвэр үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах бодлогыг дэмжиж ажиллана.
- ❖ Гудамжны гэрэлтүүлгийг үргэлжлүүлэн нэмэгдүүлж, айл хороолол хүргэж эрчимжүүлэх ажлыг дэмжиж ажиллана.
- ❖ Сургуулийн өмнөх насны хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бий болгох санал санаачлалыг дэмжинэ.
- ❖ Малчдын хүүхдийг нүүдлийн цэцэрлэгт бүрэн хамруулах тал дээр анхаарч ажиллана.
- ❖ Өрхийн түвшинд хүнсний ногоо, хүлэмж, жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх нэр төрлийг олшруулахад орон нутгийн бодлогоор дэмжиж ажиллана.
- ❖ Нутгийн залуу боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллахад орон нутгийн бодлогоор дэмжиж ажиллана.



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН Н.ГЭРЭЛЧУЛУУН

00000001